

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА
/ТӨЛӨВЛӨГӨӨ/-НЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
1	2	3	4
1	ЗДТГ болон харъяа хэлтэс албадын авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, арга зүйн нэгдсэн улирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих	Дүүргийн Засаг даргын Тамгын газар, харъяа хэлтэс, албадыг нэгдсэн удирдлагаар хангаж, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.	Тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэлтэс албадад танилцуулан тарааж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.
2	БЗД-ийн харъяа хэлтэс, албадын ХАСХОМ хариуцсан Эрх бүхий албан тушаалтнууд /ЭБАТ/- ыг мэдээлэл, арга зүйгээр ханган хамтран ажиллах.	Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг Нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан ЭБАТ-ыг мэдээллээр хангах, танилцуулага хийх.	Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг Нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан албан хаагчдыг мэдээллээр хангах, танилцуулга хийж, тус дүүргийн албан ёсны цахимд байршуулан ажилласан.
3	Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах, авлигын эсрэг сургалт, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулах	Албан тушаалтнуудад сургалт зохион байгуулах, мэдээ мэдээлэл, гарын авлигаар хангана.	Нийтийн албан тушаалтны Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө, орлогын мэдүүлэг шинэчлэн гаргах хуулийн хугацаа эхэлсэнтэй холбогдуулан мэдүүлэг гаргагч нарт зориулан ИТХ-ын ажлын алба, АТГ-тай хамтран сургалт зохион байгуулж хууль, гарын авлага тарааж хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудыг бүрэн хамруулсан.
4	Төрийн хяналтын ил тод, нээлттэй байдлыг хангах	Тухайн жилд явуулах хяналт шалгалтын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г батлан цахим хуудсанд байршуулна.	Баянзүрх дүүргийн албан ёсны https://bzd.ub.gov.mn/ цахим хуудсанд ил тод байдал цэсэнд тус дүүргийн дотоод аудитын хийх ажлын төлөвлөгөө болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг иргэд олон нийтэд нээлттэй байдлаар байршуулан ажилласан.
5		Хийсэн шалгалтын дүн, түүний мөрөөр авсан арга хэмжээний үр дүнгийн талаар цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан төлөвлөгөөний дагуу 3 дугаар улиралын байдлаар төлөвлөгөөт шалгалтыг 4-н газарт, төлөвлөгөөт бус шалгалтыг нэг байгууллагад нийцлийн болон санхүүгийн аудит хийж илэрсэн зөрчлийн дагуу нийт 4,234,453 төгрөгийг тус дүүрэг дэх төрийн сангийн хүү, торгуулийн орлогын дансанд төлүүлж, төвлөрүүлэхийг холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулан даалгаж ажилласан.

1	2	3	4
6	Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл тусламж, түүний хувиарлалтыг хуулийн хугацаанд цахим хуудсанд байршуулах	Байгууллагын төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй хариуцлагатай байдлыг хангана.	Байгууллагын төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй хариуцлагатай байдлыг ханган ажиллах асуудлын хүрээнд төсөв /гүйцэтгэл хэсэгт тухайн жилийн батлагдсан төсөв, төсвийн хэтрэлт, хэмнэлийн шалтгаан, тайлбар, санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр PDF хэлбэрээр, аудитын дүгнэлт, хандив, тусламжийн хэмжээ болон бусад орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээлэл зэргийг shilendans.gov.mn сайтад байршуулж хэвшсэн. Тус дүүргийн Орон нутгийн төсвөөс санхүүждэг 17, тусгай зориулалтын 72, өрхийн эрүүл мэндийн төв 29, хувийн цэцэрлэг 138, хувийн сургууль 19 нийт 275 байгууллагын мэдээллийг цахим хуудсанд байршуулан, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.
7		Тухайн жилийн төсөв, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг цахимд байршуулан нээлттэй мэдээлнэ.	2017 оны жилийн төсөв, дараа жилийн төсвийн төсөл, мөн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг цаг тухай бүр shilendans.gov.mn сайтад тогтмол байршуулан ажиллаж байна.
8		Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, зарцуулалтыг цахим хуудас, бусад хэлбэрээр мэдээлж иргэн, байгууллагын мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлнэ.	Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/06 дугаар тогтоолоор батлагдсан орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 27 ажлыг www.tender.gov.mn , “Үндэсний шуудан” сонин болон Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны www.bzd-procurement.ub.gov.mn цахим хуудсанд байршуулсан байна. Мөн Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, зарцуулалтыг сар бүрийн 8-ны дотор shilendans.gov.mn сайтад олон нийтийг ойлгомжтой байдлаар тогтмол байршуулан ажиллаж байна.
9	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг нээлттэй болгох	Байгууллагаас олгож буй тусгай зөвшөөрлийг холбогдох хууль, журмын дагуу олгох, хяналт шалгалтыг тогтмол явуулах.	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Захиргааны Ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.3.4 дэх заалт, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах

1	2	3	4
			<p>эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дах заалтыг тус тус үндэслэн Засаг даргын захирамжаар Аж, ахуйн нэгж, иргэнд тамхины тусгай зөвшөөрөл олгодог. Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүднээс холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран тогтмол хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан арга хэмжээ авч ажиллаж байна.</p>
10		<p>Зөвшөөрөл олгох журам, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр эрхлэх үйл ажиллагааны чиглэл, эхлэх болон дуусах хугацааг олон нийтэд нээлттэй мэдээлнэ.</p>	<p>Зөвшөөрөл олгох журам, гэрээ байгуулахад бүрдүүлэх материалын жагсаалт, тус дүүрэг дэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн судалгааг "Худалдаа үйлчилгээ баянзүрх дүүрэг" фэйсбүүк, болон https://bzd.ub.gov.mn/ цахим сайтад байршуулан ажиллаж байна.</p>
<p>Хоёр. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, хамтын ажиллагааг бэхжүүлэх</p>			
11	<p>Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>Хөтөлбөрийг иргэд олон нийт, албан хаагчдад сурталчилах, сурталчилгааны материалыг бэлтгэж түгээнэ.</p>	<p>Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг дүүргийн албан ёсны вэб сайтад байршуулсан. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн 4 төрлийн зурагт хуудас /плакат/-ыг Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх харьяа хэлтэс, албадад хүргүүлэн иргэд, албан хаагчдад хүртээмжтэй байдлаар байршуулсан. Мөн тус дүүргийн Засаг даргын Тамгын газарт Хөрөнгө орлогын мэдүүлгээ бүртгүүлдэг албан хаагчдад зориулан Авлигын эсрэг хууль тогтоомжийн эмхэтгэлийг гарын авлага болгон тараасан. 2017 оны 04 дүгээр сарын 17 оны өдрийн А/26 дугаар тушаалаар шинэчлэн боловсруулсан Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод Төрийн албан хаагчын ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлэх тусгай шаардлагыг тавьж албан хаагч нэг бүрд танилцуулан мөрдүүлэн ажиллаж байна.</p>

ТАНИЛЦСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ, ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



А.ПҮРЭВДУЛАМ

Г.БАТЦЭЦЭГ